



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 1162

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны хаалга шинэчлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Э.Халиун

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Базаррагчаа

(Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын сум хариуцсан мэргэжилтэн)

Б.Цогт-Эрдэнэ

(Шивээ Овоо хувьцаат компанийн Техник ашиглалтын инженер)

Хөндлөнгийн төлөөлөл:

Г.Даваажаргал


(Шивээ Овоо хувьцаат компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

42121413

ахуйн хэлтсийн ахлах инженер)

2. “Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны хаалга шинэчлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ